ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ГОЛОМТ БАНК

## 2026Q1 ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ТОГТВОРЖИХ ТӨЛӨВТЭЙ БА...

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
Жилийн өсөлт, хувь




**2026 оны хүлээлт :**

- Уул уурхайн салбарын өсөлт цаашид ч хүчтэй хэвээр хадгалагдах төлөвтэй бөгөөд үүнд Оюу Толгойн зэсийн олборлолт эрчимжиж, нүүрсний экспортын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.
- Засгийн газрын хэрэгжүүлж буй мега төслүүд нь барилга, эрчим хүч, худалдаа зэрэг бусад салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байгаа бол хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтжоржих төлөвтэй.

## ...ИНФЛЯЦЫН ТҮВШИН ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИНД БАЙНА

ИНФЛЯЦ БОЛОН БОДЛОГЫН ХҮҮ
2023 оны суурь үнээр




*Эх сурвалж: Монголбанк*

### Инфляцын нөхцөл байдал

- 2026 оны 3-р сарын байдлаар жилийн инфляц 7.4%-д хүрч, өмнөх сарын 6.5%-иас өссөн байна.
- **Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр** 2025 оны сүүлээс инфляц буурах чиг хандлагатай байсан хэдий ч **хүнсний бүтээгдэхүүний тогтмол өсөлт**, ялангуяа махны үнэ жилийн мөн үеэс 20.3%-иар нэмэгдсэн нь инфляцын түвшинг өсөхөд голлон нөлөө үзүүлэв.

### Инфляцын төлөв байдал

- Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт хийгээд шатахууны өртөгт нөлөөлж буй геополитикийн хүчин зүйлээс шалтгаалан инфляцын дарамт өндөр байгаа тул **2026 онд мөнгөний бодлогыг сулруулах төлөв ажиглагдахгүй байна.**
- 2027 оноос эхлэн **инфляцын зорилтот түвшинг 5% ± 2%** бууруулах төлөвтэй байна.

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ХЯТАДЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ЭРЭЛТ ТОГТВОРТОЙ ХЭВЭЭР БАЙЖ...

**2025 ЖИЛИЙН ЭЦЭС**



| ХЯТАД УЛСЫН НИЙТ НҮҮРСНИЙ ИМПОРТ | МОНГОЛ УЛСЫН НИЙТ НҮҮРСНИЙ ЭКСПОРТ (Хятадын зах зээлд эзлэх %) | Хилийн дундаж үнэ |
|---|---|---|
| **490 (▼9.8%)** Сая тонн | **90 (18.4%)** Сая тонн | **66.4$** Нэгж тонн |
| **КОКСЖИХ НҮҮРС импорт** | **НИЙТ КОКСЖИХ НҮҮРСНИЙ ЭКСПОРТ** (Хятадын импортод эзлэх %) | **Хилийн дундаж үнэ** |
| 120 (▼3.2%) Сая тонн | 60 (50%) Сая тонн | 74.1$ Нэгж тонн |
| **ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРС импорт** | **ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ ЭКСПОРТ** (Хятадын импортод эзлэх %) | **Хилийн дундаж үнэ** |
| 370 (▼12.1%) Сая тонн | 23.9 (6.5%) Сая тонн | 41.8$ Нэгж тонн |

*Эх сурвалж: Блоомберг*

## ХЯТАДЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ,

Сая тонн




*Эх сурвалж: Блоомберг*

## ...МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ ДЭМЖИЖ БАЙНА.

МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | 2025 | 2026* | 2027* | 2028* |
|---|---|---|---|---|
| **Нийт нүүрсний экспорт** | **90** | **90** | **95** | **100** |
| **Баяжуулсан** | **19** | **20** | **22** | **23** |
| Коксжих | 13 | 20 | 22 | 23 |
| **Түүхий** | **60** | **57** | **57** | **61** |
| Коксжих | 42 | 46 | 45 | 49 |
| **Эрчим хүчний** | **5** | **9** | **12** | **12** |
| **Хүрэн** | **6** | **4** | **4** | **4** |

*Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам*

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ЭКСПОРТ ИМПОРТООС ДАВЖ, ГАДААД ХУДАЛДАА ДАХИН ЭЕРЭГ ГАРАВ

### ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ
тэрбум ам.доллар




### ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
сая ам.доллар




### ГВАН
сая ам.доллар




### ВАЛЮТЫН ХАНШ
төгрөг/ам.доллар




- Хөрөнгийн орох урсгалууд (ГШХО, бонд, зээл) 2025 оны төлбөрийн тэнцлийг ашигтай гарахад дэмжлэг үзүүлсэн.
- Хэдийгээр худалдааны тэнцэл эерэг гарсан ч үйлчилгээ болон цэвэр орлогын гарах урсгалаас үүдэн урсгал данс алдагдалтай гарав.
- ЗГ-ын бонд гаргалт болон мега төслүүдийн гадаад санхүүжилт нь хөрөнгийн орох урсгалыг цаашид нэмэгдүүлнэ.
- Хувийн хэвшил, арилжааны банкуудын гадаад санхүүжилт нь хөрөнгийн орох урсгалыг дэмжиж байна.

### ТААМАГЛАЛ

**ДЭЛХИЙН ДНБ**
(2026)
**3.1%**
[ОУВС]

**ХЯТАДЫН ДНБ**
(2026)
**4.5%**
[Хятадын Засгийн газар]

**Нүүрсний үнэ**
(хил дээрх, 2026)
**$70/тонн**
[Сангийн яам]

**Зэсийн үнэ**
(2026)
**$12,410/тонн**
[Блоомберг]

**Нүүрсний экспортын хэмжээ**
(2026-2027)
**90-95 сая тонн**
[Монголын Засгийн газар]

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ГАЗРЫН ТОСНЫ ҮНИЙН ТААМАГЛАЛ/БРЕНТ НЕФТИЙН СПОТ ҮНЭ/
ам.доллар/баррель




*Эх сурвалж: Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA)*

| БРЕНТ НЕФТИЙН ҮНЭ | ДИЗЕЛЬ ТҮЛШНИЙ ҮНЭ | ШАТАХУУНЫ ҮНЭ |
|---|---|---|
| **22.0% ▲** | **16.7% ▲** | **10.6% ▲** |
| таамаглал 2026YE | таамаглал 2026YE | таамаглал 2026YE |

- 2025 онд брент нефтийн үнэ баррель нь 62.5 ам.доллар хүрсэн. Тэрээр АНУ-Израиль, Ираны дайнтай холбоотойгоор Ормузын хоолой саатсан нь нефтийн үнийг 2026 оны 3-р сарын байдлаар өмнө жилийн мөн үетэй **харьцуулахад ойролцоогоор 37%-иар нэмэгдүүлээд байгаа юм**. Үүний зэрэгцээ, Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA) 4 дүгээр сарын 2-нд гаргасан ирээдүйн хэтийн төлөвтөө нефтийн үнэ **2026 оны эцэс гэхэд баррель нь 86 ам.долларт хүрч**, улмаар 2027 онд 68 ам.доллар хүртэл буурна гэж төсөөлсөн байна.
- Ормузын хоолой хаагдсанаар Ойрх Дорнодын томоохон үйлдвэрлэгчид өдөрт 7.5 сая баррель хүртэлх олборлолтоо зогсоох хүрсэн бөгөөд 4-р сард энэ хэмжээ өдөрт 9.1 сая баррельд хүрч өссөн байна. Улмаар нийлүүлэлтийн алдагдал, тээврийн өртгийн өсөлт, мөн геополитикийн эрсдэлийн урамшууллын нөлөөгөөр Брент нефтийн үнэ **баррель нь 103 ам.долларт хүрч, цаашид 115 ам.долларт хүрэх төлөвтэй байна.**
- Хэрэв уг мөргөлдөөн 4-р сараас хойш сунжрахгүй бөгөөд нефтийн урсгал аажмаар сэргэнэ гэж үзвэл, нийлүүлэлтийн тасалдал 5-р сараас эхлэн буурч, улмаар газрын тосны үнэ 2026 оны эцэсд нэг баррель нь 90 ам.доллараас доош, **2027 онд дунджаар 76 ам.доллар орчимд тогтох боломжтой**. Гэвч өнөөгийн тодорхой бус нөхцөл байдлын улмаас нефтийн үнэ дайны өмнөх түвшнээс өндөр хэвээр байх магадлалтай.

### WTI НЕФТИЙН ҮНЭ, ам.доллар/баррель




### АЛТНЫ ХИЛИЙН ҮНЭ, ам.доллар/унц




### ЗЭСИЙН ХИЛИЙН ҮНЭ, ам.доллар/тонн




### КОКСЖИХ НҮҮРСНИЙ ҮНЭ, ам.доллар/тонн




*Эх сурвалж: Блүүмберг Экономикс*

ГОЛОМТ БАНК

*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# I УЛИРЛЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# 2026 ОНЫ 1-Р УЛИРАЛД БИД...




## ГОЛОМТ БАНК МОНГОЛ-ХЯТАДЫН БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДУГУЙ ШИРЭЭНИЙ УУЛЗАЛТАД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Тус уулзалтанд Голомт банк Монгол – Хятадын санхүүгийн хамтын ажиллагааны бодит ахиц, Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд руу чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар илтгэл танилцуулж, төлбөр тооцоо болон хөрөнгө оруулалтын талаарх үндсэн сэдвүүдэд идэвхтэй байр сууриа илэрхийлсэн юм.




## ГОЛОМТ БАНК МОНГОЛ ДАХЬ ХЯТАДЫН ЕРӨНХИЙ ХУДАЛДААНЫ ТАНХИМТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Санамж бичгийн хүрээнд талууд БНХАУ-ын бизнес эрхлэгчдэд чиглэсэн банк, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, сургалт, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхийн зэрэгцээ экспорт, импорт, хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг хөгжүүлж, худалдааны санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэхэд мэдээлэл солилцон хамтран ажиллах юм.




## ГОЛОМТ БАНК TRIPLE JUMP БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛЖ, УРТ ХУГАЦААТ САНХҮҮЖИЛТИЙГ АМЖИЛТТАЙ ТАТЛАА

Голомт банк олон улсад нэр хүндтэй, томоохон хөрөнгө оруулалтын сан болох Triple Jump байгууллагаас **5.8 сая ам.долларын** урт хугацаат санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Уг санхүүжилт нь Голомт банкны бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрхийн аж ахуй, худалдаа, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэх юм.




## ГОЛОМТ БАНК "НОГООН АРИЛЖААНЫ БАНКНЫ ЭВСЭЛ"-Д НЭГДЛЭЭ

Голомт банк Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтууд болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход анхааран ажиллаж байгаагийн хүрээнд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн дэргэдэх "Ногоон арилжааны банкны эвсэл"-д нэгдлээ. Цаашид тус эвслийн гишүүнчлэлээрээ дамжуулан бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэлхийн шилдэг туршлагаас суралцах, Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, ногоон санхүүгийн шинэлэг шийдлүүдийг дэмжих боломжууд нээгдэх юм.




## ГОЛОМТ БАНК ЭНЭТХЭГ УЛСЫН HDFC БАНКАНД АМ.ДОЛЛАРЫН ДАНС НЭЭЛЭЭ

Уг хамтын ажиллагаар эхлүүлснээр Голомт банкны харилцагчид Энэтхэг улс руу ам.долларын гүйлгээг шууд хийх боломжтой боллоо. Цаашлаад Монгол болон Энэтхэг улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ дэд бүтцийг бий болгож, улмаар иргэд, байгууллагын гадаад гүйвуулгыг илүү хурдан, найдвартай, хямд болгох юм.




## "ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ" ТӨСӨЛТЭЙ ГОЛОМТ БАНК ХАМТРАН АЖИЛЛАВ

Монголын Мянганы сорилтын сан нь Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан Мянганы сорилтын II компакт гэрээ буюу "Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх" хөтөлбөрийн хүрээнд уг төсөл хэрэгжсэн бөгөөд банкны зүгээс нийт 19.5 сая ам.долларын урьдчилгаа төлбөр болон гүйцэтгэлийн баталгаа олгон хамтран ажилласан байна.

# ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

АЛТНЫ ФОРУМ 20 26

7 ДАХЬ ЖИЛДЭЭ



## АЛТНЫ ФОРУМ 2026

Арга хэмжээний үеэр эдийн засаг хийгээд зах зээлийн нөхцөл байдал, тэр дундаа алтны салбарт нөлөөлөх алт арилжаа болон алт олборлолт, шатахууны үнийн өөрчлөлтийн талаар олон улсын шинэ мэдээ, судалгааг мэргэжилтнүүд зочдод хүргэсэн юм. Мөн энэ жилийн хэлэлцүүлгийг "Уул уурхайн салбарын санхүүжилт: Боломж, эрсдэл, бодлогын уялдаа" сэдвээр өрнүүлж, модератороор Эрдэнэ Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Билгүүн оролцлоо. Арга хэмжээнээс онцлох бас нэгэн үйл ажиллагаа нь хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмж нийлүүлэгч, худалдаалагч байгууллагуудын нээлттэй бүүтүүд ажилласан үзэсгэлэнгийн хэсэг байлаа. Энэхүү үйл ажиллагаа нь оролцогч, зочдод шинэ тоног төхөөрөмжүүдтэй газар дээр нь танилцан, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаа эхлүүлэх боломжийг олгосон юм.

**ТООН МЭДЭЭ :**

**300**
ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ

**450**
ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН
(2025 оны байдлаар)

# ДИЖИТАЛ БАНКНЫ ХҮРЭЭНД...

## ХЭРЭГЖИЖ ДУУССАН АЯНУУД

3 хөтөлбөр




## ХЭРЭГЖИЖ БУЙ АЯНУУД

12 хөтөлбөр




## PAYSEND & VISA DIRECT P2P

Олон улсын шилжүүлэг



# ДИЖИТАЛ БАНК

## PAYSEND & VISA DIRECT P2P НЭВТРҮҮЛЭЛТ

Голомт банк харилцагчдынхаа олон улсын төлбөр тооцооны хэрэгцээнд нийцсэн, найдвартай, орчин үеийн дижитал санхүүгийн шийдлүүдийг тасралтгүй санал болгож ирсэн. Энэ хүрээнд олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тэргүүлэгч Visa Worldwide Pte. Limited-ийн **Visa Direct P2P** болон Paysend PLC байгууллагын **Paysend** үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, харилцагчдадаа олон улсын шилжүүлгийг илүү хялбар, найдвартай гүйцэтгэх боломжийг олгож байна. Ингэснээр харилцагчид SocialPay аппликэйшнийг ашиглан өөрийн Голомт банкны данснаас олон улсын банкны данс болон карт руу гадаад гүйлгээ, шилжүүлгийг гар утсаараа түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой боллоо.



# ДИЖИТАЛ БАНК

## ЛОЯАЛТИ БОЛОН УРАМШУУЛАЛТ ХӨТӨЛБӨРҮҮД




**30к**
ХАРИЛЦАГЧ

**123сая**
ТӨГРӨГНИЙ КУПОН ОЛГОЛТ

**220сая**
ТӨГРӨГНИЙ БУЦААН ОЛГОЛТ

### ХЭРЭГЖИЖ БУЙ АЯНУУД

12 хөтөлбөр



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД







## ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ ТӨСӨЛ

Голомт банк нь нийгмийн хариуцлагын хүрээнд түүхэн дурсгалыг судлан хамгаалах, Монголынхоо түүхийг ирээдүй, хойч үедээ үнэн бодитоор өвлүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулах зорилгоор ШУА-ийн Археологийн хүрээлэн, Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран "Өв соёлын голомт" төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд Монголын түүх, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий нийт 3000 гаруй олдворуудыг нээн илрүүлсэн ба цухас дурдвал:

- Бадам цэцгэн хээтэй нүүр ваар;
- Алтан зоос (Монголд илэрсэн 2 дахь алтан зоос);
- Үйсэн дээрх бичиг зэрэг эд өлгийн олдворууд байгаа билээ.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД







## ГОЛОМТ БАНК “БУМБАТЫН ХӨВ ЦӨӨРМИЙН ТӨСӨЛ”-Д НЭГДЛЭЭ

Монгол Улсын “УСНЫ ЭЛЧ” банк болсныхоо хүрээнд Улаанбаатар хотын гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх ХӨВ ЦӨӨРӨМ байгуулах ажлыг санхүүжүүлэхээр боллоо.

Монгол орны гадаргын усны нөөцийн 80 хувь нь нуурaас бүрддэг боловч уур амьсгалын өөрчлөлт болон бохирдлын улмаас экосистемийн тэнцвэр алдагдах болсон. Иймд “Бумбатын хөв цөөрмийн төсөл” нь усны нөөцийг хамгаалах, усны зохистой хэрэглээ, дахин ашиглалтыг дэмжих замаар тогтвортой усны менежмент, экосистемийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.










## ГОЛОМТ БАНК “УСНЫ ЭЛЧ” БАНКААР ДАХИН ӨРГӨМЖЛӨГДӨВ

(Онцлох үйл явдал: Усны дэд бүтэц сайжруулалтын хүрээнд нийт 21.9 тэрбум төгрөгийн санжүүжилт олгов.)



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД










## ГОЛОМТ БАНК "ҮНДЭСНИЙ ХИЙМЭЛ ОЮУНЫ АЯН"-ЫГ ДЭМЖИН АЖИЛЛАНА

Сайн сайхныг санхүүжүүлэх, санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд "AI Academy Asia" байгууллагаас санаачлан үндэсний хэмжээнд 2025-2030 он хүртэл хэрэгжүүлж буй 5 жилийн хугацаатай Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж байгаа ЕБС-ийн багш нарыг чадавхжуулах, хиймэл оюуны 2,500 хүний нөөц бэлтгэх хөтөлбөрийг дэмжин ажиллахаар боллоо. Уг хөтөлбөрөөр :

- 500 багш;
- 20,000 сурагчдад хиймэл оюуны мэдлэгийг түгээж, сурагчдыг технологид суурилсан эдийн засагт амжилттай оролцох ирээдүйн ур чадварт бэлтгэхэд зорьж байна.




## "INSIGHTS by GOLOMT BANK"

Санхүү, эдийн засаг, зах зээлийн мэдээ мэдээллийг салбарын мэргэжилтнүүдийн тайлбар, дүгнэлттэйгээр хүргэж, олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих үндсэн платформыг бүтээж байна.






ГОЛОМТ БАНК



ГОЛОМТ БАНК

# I УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

# САНХҮҮГИЙН ҮР ДҮН

## ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ




Нийт хөрөнгө ▼ 4.5%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29% (2023-2025)




Нийт зээл ▼ 2.1%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 31%




Татан төвлөрүүлсэн хөрөнгө ▼ 5.8%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29%




*Монголбанк тайлангийн суурьтай*

# ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Нийт зээлийн бүтээгдэхүүн** ▼2.1%
/тэрбум төгрөг/




**Хэрэглээний зээл** ▼0.2%
/тэрбум төгрөг/




**Чанаргүй зээлийн харьцаа**
/хувь/




**Бизнесийн зээл** ▼ 6.1%
/тэрбум төгрөг/




**Орон сууцны зээл** ▲7.7%
/тэрбум төгрөг/




**Чанаргүй зээлийн сангийн хүрэлцээ**
/хувь/




*Монголбанк тайлангийн суурьтай*

# ХАРИЛЦАГЧДААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР

**Нийт харилцах, хадгаламж** ▲ 5.0%
/тэрбум төгрөг/




**Хадгаламж** ▲ 6.5%
/тэрбум төгрөг/




**Харилцах** ▲ 2.9%
/тэрбум төгрөг/




**Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**
/хувь/




**Зээл, эх үүсвэрийн харьцаа**
/хувь/




*Монголбанк тайлангийн суурьтай*

# САНХҮҮГИЙН ҮР ДҮН

**Цэвэр ашиг**
/тэрбум төгрөг/




**Өөрийн хөрөнгө**
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 28%




**Өөрийн хөрөнгийн хүрэлцээ**
/хувь/




**Холбоотой этгээдэд олгосон зээл**




**Холбоотой этгээдэд олгосон зээл**




**Гадаад валютын эрсдэлийн харьцаа**
/хувь/




*Монголбанк тайлангийн суурьтай*

# ҮНЭТ ЦААСНЫ ГҮЙЦЭТГЭЛ, НОГДОЛ АШИГ ОЛГОЛТ

## MSE:GLMT Хувьцаа

Хоёрдогч зах зээлийн хувьцааны ханш




## SGX:GLMTMO27 Бонд

Хоёрдогч зах зээлийн бондын ханш




## Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашиг

**80**
**ТӨГРӨГ**

| | |
|---|---|
| 330.4 ТЭРБУМ ТӨГРӨГ | 2025 ОНЫ ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ |
| 19.58% | 2025 ОНЫ ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ХУВЬ ХЭМЖЭЭ |
| 64.7 ТЭРБУМ ТӨГРӨГ | ХУВААРИЛАХ НИЙТ ДҮН |

**2025/02/13**

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР ГАРСАН.

**2026/04/27**

НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНС РУУ ШИЛЖҮҮЛЭХ ӨДӨР.

# БАЯРЛАЛАА

https://www.golomtbank.com/investor-relations

investornews@golomtbank.com

1800-1646